

**ХОВД АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛД
БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ МАРХАВАЙГИЙН КИСТАУВАЙН
МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

ЭРХЭМ ЗОРИЛГО

ЭЦЭГ ӨВГӨДӨӨС ӨВЛҮҮЛЭН ҮЛДЭЭСЭН ХОВД НУТГИЙНХАА ОЛОН ҮНДЭСТЭН, ЯСТАН ИРГЭДИЙНХЭЭ ХӨДӨЛМӨРЧ БҮТЭЭЛЧ УЛАМЖЛАЛ, ГАЗАР ШОРОО БАЙГАЛЫН БАЯЛАГ, НӨӨЦӨД ТҮШИГЛЭН ЭДИЙН ЗАСАГ, БЕЗНИСИЙН ТААТАЙ ОРЧИН БҮРДҮҮЛЖ, ҮЙЛДВЭРЛЭЛ, ҮЙЛЧИЛГЭЭ ХӨГЖСЭН, АРД ИРГЭДИЙН ҮНДЭСНИЙ УЛАМЖЛАЛТ ЁС, ЗАН ЗАНШЛЫГ ХАДГАЛЖ, ХҮНИЙ ХӨГЖЛИЙГ ХАНГАСАН АЙМАГ БОЛНО.

Зорилт-1 Боловсролын салбарт


1. Малчдын хүүхдийг сургуульд бэлтгэх багт гэр цэцэрлэг ажиллуулах замаар сургуулийн өмнөх боловсролын хүрээг өргөтгөнө.
2. “Хүүхэд бүр цэцэрлэгт” хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлж хувийн цэцэрлэгийн үйл ажиллагааг дэмжиж, хамран сургалтыг нэмэгдүүлнэ.
3. Хүн амын боловсролын түвшинг дээшлүүлэхэд албан ба албан бус сургалтын хэлбэрийг өргөн ашиглаж, сургуулийн насны хүүхдийн хамралтыг 99%-д хүргэнэ. Сургууль завсардсан хүүхдүүдийг гэрээр сургах нөхцөл бололцоог дэмжиж ажиллана.

Зорилт-2 Соёлын салбарт

1. Үндэсний өв соёлоо дээдлэх, хайрлан хамгаалах, өсвөр хойч үедээ уламжлуулах, үндэсний өв соёлоороо бахархах үзлийг иргэдэд төлөвшүүлэхэд соёл урлагын байгууллагуудтай хамтран ажиллана.
2. Олон ястаны өвөрмөц зан заншил, өв соёлыг өвлүүлэн үлдээх зорилгоор өрх бүр ургийн бичиг хөтлөх аяныг өрнүүлж ажиллана.
3. Хүүхэд, залуучууд, ахмад, эмэгтэйчүүд, малчид, тариаланчдын чуулга уулзалтыг уламжлал болгон зохион байгуулна.

Зорилт-3 Эрүүл мэндийн салбарт

1. Иргэн бүр эрүүл мэндийн бүрэн оношилгоонд жил бүр заавал хамрагдах тогтолцоог бүрдүүлнэ.
2. Иргэдэд үзүүлэх эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх, эмчилгээ үйлчилгээг шаардлагын хэмжээнд хүргэн ажиллана.
3. Ховд аймагт “Элэг бүтэн Монгол” хөтөлбөрийг үргэлжлүүлж, “Хавдрын эсрэг хамтдаа” хөтөлбөр хэрэгжүүлнэ.



4. Иргэд идэвхтэй хөдөлгөөн хийх, уулын болон явган аялал, дугуйн спорт зэрэг нийтийн биеийн тамирын төрлүүдийг дэмжиж, хамрах хүрээг өргөжүүлнэ.

Зорилт-4. Хөдөө аж ахуйн салбарт

1. Хөдөө аж ахуйн салбарт малчид, тариаланчдын залгамж халааг бэлтгэх бодлого хэрэгжүүлнэ.
2. “Ховд агро парк” цогц төслийг хэрэгжүүлнэ.
3. Малын үүлдэр угсааг сайжруулах бодлогыг тусгайлан дэмжиж, цөм сүрэг бий болгоно.
4. Мал сүргийн тоо, төрлийн зохистой харьцааг бүрдүүлж бэлчээрийн усан хангамж, даацад тохирсон мал аж ахуйг эрхлэх бололцоог малчдад бүрдүүлэн ажиллана.
5. Малчин өрхүүдийг хадлангийн талбайтай болгоно.
6. Усны эрэл хэрэгцээтэй байгаа газруудад гар болон инженерийн хийцтэй худаг гаргана.
7. Ноос ноолуур, арьс, шир болон малаас гарч буй дайвар бүтээгдэхүүн зэргийг боловсруулах үйлдвэрүүдийг дэмжиж ажиллана.
8. Газар нутгын маргаантай байгаа хилийн цэсийг шийдвэрлэхийн төлөө холбогдох газруудад уламжлан ажиллана.
9. Импортын ногоог хязгаарлах бодлого боловсруулж, сумын тариаланчдаа дэмжиж баруун бүсийг төмс хүнсний ногоогоор бүрэн хангах зорилт тавин ажиллана.
10. Үр тариа, тэжээлийн ургамал тариалах ажлыг дэмжиж, төмс хүнсний ногоо хадгалах, борлуулах сулжээ бий болгоно.

Зорилт-5 Нийгмийн хамгааллын салбарт

1. Ахмад, хөгжлийн бэрхшээлтэй, өрх толгойлсон зэрэг иргэдийг дэмжиж, нийгмийн харилцаанд идэвхитэй оролцуулж, тэдний эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бий болгон ажиллана.
2. Орлого багатай өрхийн нийгмийн хамгаалал, амьжиргааг дээшлүүлэх олон нийтийн оролцоонд түшиглэсэн бодлогыг хэрэгжүүлнэ.
3. Хүүхдийн хөгжил, авьяас, ур чадвар, техник сэтгэлгээ, нийгмийн төлөвшилтийг дэмжихэд эцэг, эхчүүдийн оролцоог нэмэгдүүлнэ.
4. Хүүхдийн эрх, хөгжил, хамгааллын тогтолцоог бэхжүүлж, хүүхэд, гэр бүлд ээлтэй, тэгш боломж бүхий нийгмийн хамгааллын бодлогыг хэрэгжүүлнэ.

Зорилт- 6. Байгаль орчин хамгаалах салбарт



[Signature]

1. Булаг шандууд ширгэж усгүй болж байгаа учир малчид, ард иргэдтэй хамтран хамгаалах, мод тарих ажлуудыг зохион байгуулна.
2. Гол, горхи, булаг, шанд, рашааны ундаргын эхийг хамгаалах ажлыг эрчимжүүлж, ус хуримтлуулах, усан сан, хөв, цөөрөм байгуулах замаар гүний усны хэрэглээг бууруулна.
3. Хог хаягдалтай тэмцэж ажиллана.

Зорилт- 7. Аялал жуулчлал, амралт сувилалын салбарт

1. Орон нутгийн аялал жуулчлалыг дэмжиж ажиллана.
2. Аялал жуулчлал, амралт сувилалыг үйлчилгээний иж бүрэн салбар болгон хөгжүүлнэ.
3. Байгалын сонин тогтоцтой газар, уул ус, ан агнуур, түүх соёл, урлаг зэрэг бүх төрлийн аялал жуулчлал хөгжүүлэхийг дэмжиж ажиллана.
4. Орон нутгийн аялал жуулчлалын чиглэлээр аймгийн нэгдсэн маршрут гаргах, үзэсгэлэнт газруудаар кино, видео бичлэг хийлгэж хойч үедээ өвлүүлэн үлдээнэ.

Зорилт-8. Гадаад харилцааны салбарт

1. Эрүүл мэнд, боловсрол, байгаль орчин, урлаг соёл, мал аж ахуй, газар тариалангийн талаарх гадаад харилцааг улам өргөжүүлж, хамтран ажиллана.

Зорилт-9. Нутгийн удирлагын салбарт

1. Төрөөс иргэдэд үзүүлэх үйлчилгээг ил тод нээлттэй болгож, орон нутгийн хариуцлагатай засаглалын төлөөх иргэний оролцоог нэмэгдүүлж, ил тод үүрэгжсэн нийтийн албыг бий болгоно.
2. Боловсон хүчнийг сургаж дадлагажуулах замаар төрийн албан хаагчдын чадавхийг дээшлүүнэ.
3. Нутгийн удирдлага, захиргааны байгууллагаас дэвшүүлсэн хөтөлбөр зорилтыг хэрэгжүүлэхэд иргэний нийгмийн болон хувийн хэвшлийн байгууллагын бодит санал санаачилга, төсөл хөтөлбөрийг дэмжиж хамтран ажиллана.

Зорилт-10 Эрх зүйн салбарт


1. Байгаль орчин болон малын хулгайтай тэмцэх ажлуудыг Цагдаагийн байгууллага, малчидтай хамтран жил бүр зохион байгуулна.
2. "Архигүй, тамхигүй Ховд" хөтөлбөрийг сум орон нутагт зохион байгуулна.
3. "Хууль. Журам миний-амьдралд" аяны хүрээнд хууль эрх зүйн мэдээлэл түгээх ажлыг улирал бүр иргэний нийгмийн төлөөлөл, албан байгууллагуудтай хамтран зохион байгуулж, бүх нийтийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлнэ.

8117143332
54



4. Авлигын эсрэг болон Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулиар хүлээлгэсэн үүргийн биелэлтийг хангуулж ажиллана.
5. Хууль тогтоомжийг сурталчлах тайлбарлан таниулах, эрх зүйн сургалт сурталчигаа мэдээллийн ажлыг тогтмол явуулж, иргэдийн нийгмийн амьдралд оролцох эрх, үүргээ хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

Таны итгэлээр бидний зүтгэлээр

Төрлөх нутгаа хөгжүүлье.



МӨРИЙН ХӨТӨЛБӨР БОЛОВСРУЛСАН:

ХОВД АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛД
БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ  М.КИСТАУВАЙ

УТАС: 99664427